

## ШМТДС-ИЙН ЗАЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Боловсруулсан: Сургалтын алба  
Дэмжсэн: Захирлын зөвлөл  
Баталсан: ШМТДС-ийн сургалт эрхэлсэн захирал

|                    |                 |
|--------------------|-----------------|
| Эхний хэвлэлт      | 2020.04.14 А/10 |
| Өөрчилсөн огноо    | 2020.11.12 А/28 |
| Өөрчилсөн огноо    | 2024.01.22 А/02 |
| Өөрчлөлтийн дугаар | 3               |

## Агуулга

|  |   |
|--|---|
| НЭР ТОМЪЁО.....                                    | 3 |
| НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....                             | 4 |
| УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....                  | 4 |
| ЗАЙН СУРГАЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА .....           | 5 |
| ЗАЙН СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦ .....                       | 6 |
| ОЮУТНЫ ҮНЭЛГЭЭ.....                                | 6 |
| ПРОФЕССОР БАГШИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ..... | 6 |
| БАГШ ОЮУТНЫ ЭРХ, ҮҮРЭГ .....                       | 7 |
| БУСАД.....   | 8 |

## НЭР ТОМЬЁО

**Дээд боловсролын зэрэг (Higher education degree)** нь багц цагаар хэмжигдэх дэд бакалаврын, бакалаврын, магистрын, докторын зэрэг, шатлалыг хэлнэ.

**Багц цаг (Credit)** нь боловсролын агуулгын багтаамжийг жиших нэгж бөгөөд суралцагчийн сурах ачаалал, багшийн сургалтын ажлын хэмжээ, сургалтын төлбөрийг тогтоох үндсэн хэмжүүр.

**Хичээлийн багц цаг (Course credit)** нь хичээлийн агуулгыг илэрхийлэх тоон хэмжээ.

**Хичээлийн цаг (Class time)** гэдэгт танхимд завсарлахгүйгээр хичээллэх бодит цаг.

**Зайн сургалт (Distance learning)** Оюутан суралцагчийг сургуулийн анги танхимд сургах шаардлагагүйгээр лекц, семинар, лабораторийг интернетээр шууд дамжуулж, зориулалтын програм хэрэглэн сургах е-сургалт.

**Сургалтын хөтөлбөр (Curriculum).** Оюутанд тухайн дээд боловсролын зэрэг олгоход шаардагдах мэдлэг, чадвар, хандлагыг сургахад зориулж боловсруулсан, иж бүрэн бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг тодорхойлсон баримт бичиг.

**Үндсэн хөтөлбөр (Major).** Оюутны суралцах үндсэн чиглэл буюу тухайн шинжлэх ухааны тодорхой мэдлэг, чадвар, дадлыг заавал болон сонгон суралцах хэлбэрээр боловсролын зэрэг олгох түвшинд эзэмшүүлэх зорилготой сургалтын хөтөлбөр.

**Хос хөтөлбөр (Double Major).** Тодорхой болзол хангасан оюутанд суралцаж буй үндсэн мэргэжлийн хөтөлбөрөөс гадна өөр чиглэлээр хоёр дахь мэргэжлийг эзэмшүүлэх зорилготой хөтөлбөр.

**Сургалтын төлөвлөгөө (Study plan).** Хөтөлбөрийн гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд судлах хичээлийн жагсаалт, агуулгын багтаамж, дарааллыг тусгасан баримт бичиг.

**Хичээлийн хөтөлбөр (Syllabus)** нь сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүрийн индекс, суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадварын агуулга, сэдэвчилсэн төлөвлөгөө, үнэлгээ, арга зүй, тухайн хичээлийн багц цаг, ашиглавал зохих ном, сурах бичиг, эх сурвалжийн жагсаалтыг тодорхойлсон баримт бичиг.

**Хичээлийн индекс (Course index).** Хичээл бүр бусад хичээлээс ялгагдах, тухайн хичээлийг илтгэх тусгай тэмдэглэгээ.

**Оюутны мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээ.** Оюутны судалсан хичээл бүрээр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагын түвшинг илэрхийлэх тоон болон үсгэн үзүүлэлт.

**Голч дүн (GPA).** Оюутны мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээний чанарыг илтгэх тоон үзүүлэлт.

**Оюутны идэвхтэй төлөв.** Тухайн улиралд сургалтын төлбөр төлж, хичээл сонголтоо хийж суралцах эрхээ авсан оюутан.

**Оюутны идэвхгүй төлөв.** Тухайн улиралд сургалтын төлбөр төлөөгүй, хичээл сонголтоо хийгээгүй, жилийн болон улирлын чөлөө авсан оюутан.

## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

2023 оны 7-р сарын 7-нд батлагдсан Монгол Улсын Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, журамд үндэслэн Шинэ Монгол Технологийн Дээд Сургууль (цаашид ШМТДС гэнэ) дээд боловсролын бакалавр болон магистрын зэрэг олгох зайн сургалтыг зохион байгуулах, оюутан элсүүлэх, тэдний мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх, дипломын төсөл, ажил хамгаалуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

- 1.1 Зайн сургалтыг зохион байгуулах үйл ажиллагааны зорилго нь Сургуулийн бүх шатны сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлээс суралцахаар төлөвлөсөн оюутанд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран боловсролын үйлчилгээг хүргэх боломжийг бий болгоход оршино.
- 1.2 Зайн сургалтын үндсэн хэлбэр нь лекц, семинар, лаборатори, бие даалт, сорил, шалгалтаас бүрдэнэ. Онолын мэдлэгийг онлайн лекцээр, харин мэдлэгээ бататгах, хэрэглэх чадварыг лайв хэлбэрээр семинар болон лабораторийн хичээлүүдээр олгоно.
- 1.3 Зайн сургалт явуулсан үндсэн багшийн ажлын гүйцэтгэлийг “ШМТДС-ийн багшийн ажлын үнэлгээний журам”-ыг үндэслэн тооцно.
- 1.4 Энэ түр журмыг Сургуулийн үндсэн профессор, багш, цагийн болон гэрээт багш, оюутан болон бусад оролцогчид дагаж мөрдөнө.

## УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1 Сургуулийн захиргаа зайн сургалт явуулах бодлого боловсруулах, зохион байгуулалт хийх, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, зайн сургалтын материал бэлтгэх орчин бүрдүүлэх, зайн сургалтын чанарт үнэлгээ хийх зэргээр зайн сургалтын үйл явцыг тасралтгүй сайжруулах ажлыг удирдан зохион байгуулна.
- 2.2 Чанарын дотоод баталгаажуулалтын алба дараах чиг үүрэгтэй ажиллана:
  - 2.2.1 Зайн сургалтын өдөр тутмын үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянана.
  - 2.2.2 Зайн сургалтын чанарын талаар оюутнуудаас улирал тутамд сэтгэл ханамжийн
  - 2.2.3 судалгаа авч, анализ хийнэ.
- 2.3 Сургалтын алба: дараах чиг үүрэгтэй ажиллана:
  - 2.3.1 Зайн сургалтын үйл ажиллагааг Захирлын зөвлөлөөс өгсөн тогтоол, шийдвэр, чиглэлийн дагуу зохион байгуулах;
  - 2.3.2 Багш, оюутны саналыг үндэслэн зайн сургалтын хичээлийн хуваарийг болон зайн сургалтын контент боловсруулах студийн хуваарь зохиох,
  - 2.3.3 Оюутнуудад зайн сургалтын хичээлийн төлөвлөгөө, хуваарийг хүргүүлэх, хичээлд оролцох бэлтгэлийг хангуулах,
  - 2.3.4 Олон нийтэд зайн сургалтын талаар мэдээлэл түгээх;
- 2.4 Зайн сургалтын үйл ажиллагаанд Хөтөлбөрийн хороо дараах чиг үүрэгтэй ажиллана:
  - 2.4.1 Зайн сургалтын хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, агуулга, заах арга зүй, ашиглах эх

- сурвалжтай урьдчилан танилцаж батлах,
- 2.4.2 Зайн сургалтын хичээлийн агуулга нь сургалтын үндсэн хөтөлбөр, төлөвлөгөөтэй нийцэж буйг хянах, хичээл хоорондын үялдаа холбоо, зайн сургалтын хичээлд тавигдах шаардлагыг хангаж буй эсэхэд үнэлгээ өгч, сайжруулахад чиглүүлэн ажиллах.

## ЗАЙН СУРГАЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1 Зайн лекц, семинар, лаборатори хичээлийн материалыг **Google classroom**-д байршуулна. Лекц, семинар болон лаборатори хичээлийг **Google meet** програм ашиглан лайваар явуулна. Шалгалт болон сорилыг **Google forms** ашиглан авна.
- 3.2 Зайн сургалтын тухайн хичээлийн сэдвийн агуулгыг оновчтой, сонирхолтой, ойлгомжтой хэлбэрээр сургалтын идэвхтэй аргыг хэрэглэн Монгол хэлнээ боловсруулсан байхыг шаардана.
- 3.3 **Google classroom**-д байршуулах хичээл бүр дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:
- 3.3.1 Видео хичээл (Сургуулийн логотой байна),
  - 3.3.2 PPT тайлбар (Header хэсэгт сургуулийн нэр бичигдсэн байна),
  - 3.3.3 Унших материал (гар бичмэл, гарын авлага, сурах бичиг, лабораторийн заавар, бодлогын хураамжийн тодорхой хуудсуудыг хуулбарласан PDF материалууд),
  - 3.3.4 Бататгах хэсэг (Хугацаат даалгавар, бие даалтаар хийх дасгал, төсөл, туршилт гэх мэт)
  - 3.3.5 Түвшин тогтоох сорил, явцын сорил, улирлын шалгалтын материал.
- 3.4 Видео хичээл нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 3.4.1 Видео хичээлийн нэг файлын үргэлжлэх хугацаа хамгийн ихдээ 20 минут байна.
  - 3.4.2 Видео хэлбэрээр оюутанд өгөх лекц, семинарын үргэлжлэх хугацаа 60 минут байх ба нэгж лекц, семинар нь 1-3 хэсэг видео файлаас бүрдэж болно.
  - 3.5.1 Видео хичээл нь \*.mp4 өргөтгөлтэй байх, нэг секундэд 30 кадртай (fps) байх, дүрс нь 16:9 өндөр өргөний харьцаатай байх, 1280x720 дүрсний нягтралтай байх шаардлагатай.
- 3.5 Лекцийн хичээлийн агуулгыг тайлбарласан текст файлыг PDF хэлбэрээр заавал байршуулна. PDF файл нь гар бичмэл байж болох бөгөөд уншигдахаар хуулбарлаж байршуулна.
- 3.6 Зайн сургалтын бие даалт, даалгаврыг хийх зааварчилгаа нь жишээ, бодлого, тайлбартай, оюутанд ойлгомжтой товч, тодорхой байна.
- 3.7 Семинар, лабораторийн хичээлийг лайв ашиглан идэвхтэй сургалтын аргаар явуулж оюутантай амьд харилцаа үүсгэж, лекцээр олж авсан мэдлэгээ бататгах байдлаар явуулна.
- 3.8 Лабораторийн хичээлийг дараах хэлбэрүүдээр явуулна. Үүнд:
- 3.8.1 Видео болон лайв хэлбэрээр лабораторид туршилт хийж үзүүлэх
  - 3.8.2 Симуляцийн програм ашиглан туршилт, судалгаа хийх
  - 3.8.3 Интернет дэх нээлттэй эх сурвалжтай туршилт-видео хичээлийг ашиглах
- 3.9 Зайн сургалтын шалгалтын материалыг дараах хэлбэрүүдээр бэлтгэхийг шаардана. Үүнд:
- 3.9.1 Хариулт нь 4-өөс доошгүй сонголттой байх (Multiple choice)
  - 3.9.2 Богино хариулт бичиж явуулах хэсэг (Short answer)
  - 3.9.3 Олон сонголттой хариулттай (Check boxes)

- 3.9.4 Хариулт файлаар илгээх (File upload)
- 3.9.5 Харгалзуулах (Multiple choice grid)
- 3.9.6 Лайв хэлбэрийн шалгалт шүүлэг
- 3.9.7 Төслийн тайлан, реферат бичвэр

## ЗАЙН СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

- 4.1 Багш зайн сургалтын хичээлийг энэ журмын 3 дугаар зүйлд заасан бүтэцтэй бэлтгэн **Google classroom**-д хичээл орох хуваарьт өдрөөс 2-3 өдрийн өмнө байршуулсан байна.
- 4.2 Багш **Google classroom**-д байршуулсан хичээлийн дагуу оюутнуудтай лайв ашиглан идэвхтэй сургалтын аргаар мэдлэг, үр чадвар олгоно.
- 4.3 Зайн сургалтын лекц, семинар, лабораторийн хичээлийн болон сорил, шалгалтын үед багшийг шаардах үед оюутан өөрийн дүү болон дүрсээ өгч харилцан ярилцана.
- 4.4 Багш тухайн хичээлийг явуулахад Google classroom-д байршуулсан бүх материал, оюутантай чаталж зөвлөгөө өгсөн бүх зүйлсийг файлаар баримт болгон Сургалтын албанд хадгалуулна.
- 4.5 Хөтөлбөрийн хороо зайн сургалт явуулсан үйл явцад дүгнэлт хийж санал зөвлөмж гаргана.

## ОЮУТНЫ ҮНЭЛГЭЭ

- 5.1 Зайн сургалтын лекц, семинар, лаборатори, бие даалтын хичээлүүдэд оролцсон оюутан бүрийг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:
  - 5.1.1 Google meet хэрэглэсэн үед хичээлд оролцсон хугацаа болон идэвхтэй оролцоог үнэлнэ,
  - 5.1.2 Google meet хэрэглээгүй үед хичээл бүрийн ойлгомжгүй хэсэгт оюутан бүрийн бичсэн коммент болон асуусан асуултыг үнэлнэ,
  - 5.1.3 Хичээлийн сэдэв бүрээр ойлголтын түвшин тогтоох сорилын үнэлгээ,
  - 5.1.4 Оюутан бүр зайн сургалтын хичээлийн агуулгаар хоёр удаа өгсөн сорилын үнэлгээ өгнө,
  - 5.1.5 Оюутан багшийн өгсөн хугацаат даалгавар, бие даалтын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ өгнө,
  - 5.1.6 Шалгалтын үнэлгээ хийгдэнэ.
- 5.2 Лайв хэлбэрийн хичээлд хүндэтгэх шалтгаанаар хамрагдаагүй оюутанд тодорхой даалгавар өгч, тухайн хичээлийг бие даан судалсаныг үнэлнэ.
- 5.3 Оюутны эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл хэлэлцүүлэх, дүгнэх асуудлыг тухайн тэнхим үнэлнэ.

## ПРОФЕССОР БАГШИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

- 6.1 Зайн сургалтын хугацаанд багш энэ журмын 3, 4, 5 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу зайн сургалт явуулсныг Сургалтын албанаас баталгаажуулсан тохиолдолд хичээл заасанд тооцож багшийн ажлын А цагийн тооцоо хийнэ.
- 6.2 Багшийн ажлын Б цагийг тооцохдоо дараах шаардлагыг хангасан байхыг шаардана. Үүнд:
  - 6.2.1 Оюутны илгээсэн коментод хариу илгээж, анализ хийсэн байх,
  - 6.2.2 Оюутантай эргэх холбоотой ажилласнаа баримтжуулсан байх,
  - 6.2.3 Зайн шалгалтын материалыг энэхүү журмын дагуу боловсруулж, үнэлгээнд анализ хийсэн байх,
  - 6.2.4 Идэвхтэй сургалтын арга хэрэглэсэн байх,
  - 6.2.5 Багш зайн сургалтын дараа өөрийн үнэлгээний тайлан хэлэлцүүлж, үнэлэлт дүгнэлт авсан байх,
  - 6.2.6 Зайн сургалтын багц материалыг сургалтын албанд хүргүүлж, зайн сургалтын архивт байршуулсан байх.

## **БАГШ ОЮУТНЫ ЭРХ, ҮҮРЭГ**

- 7.1 Зайн сургалтын үед профессор багш дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
  - 7.1.1 Зайн сургалтын хичээлийн материал бэлтгэх, хичээлийн агуулгыг заах, сайжруулах, зайн сургалтын үр дүнг тайлагнах, сан үүсгэх үүрэгтэй,
  - 7.1.2 Явцын болон улирлын шалгалтын материал бэлтгэж, тэнхмийн эрхлэгчид хянуулан, батлуулах үүрэгтэй,
  - 7.1.3 Зайн сургалтанд оюутан хэрхэн хамрагдах, сургуулийн e-мэйл хаяг, Google classroom, Google meet, Google forms, симуляцийн програм зэрэг зайн сургалтын технологиудыг хэрхэн ашиглах зааврыг өгөх үүрэгтэй,
  - 7.1.4 Сургуулийн захиргаа, Хөтөлбөрийн хороо болон Сургалтын албанаас зайн сургалтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмж, тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй,
  - 7.1.5 Зайн сургалтын талаар мэдээ, мэдээлэл, зөвлөмж чиглэл авах эрхтэй,
  - 7.1.6 Зайн сургалтыг явуулах нөхцөл боломжоор хангуулах эрхтэй.
- 7.2 Зайн сургалтын үед оюутан дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
  - 7.2.1 Зайн сургалтын аль ч хичээлийн үед оюутан суралцагч анги танхимд хичээллэж байгаа мэт ширээний ард сууж, өөрөө төвлөрч хичээллэх орчинг үүсгэж суралцах үүрэгтэй,
  - 7.2.2 Зайн сургалтын хичээлд хамрагдах нөхцөлийг оюутан өөрөө бүрдүүлсэн байх үүрэгтэй,
  - 7.2.3 Багшийн Google classroom-д байршуулсан зайн сургалтын материалыг судалж, хичээлд заавал оролцох үүрэгтэй,
  - 7.2.4 Хүндэтгэх шалтгааны улмаас сургалтад хамрагдах боломжгүй тохиолдолд Google classroom-д буй Сургалтын албаны мэргэжилтэнд болон багшид чөлөө авах хүсэлт илгээх үүрэгтэй,
  - 7.2.5 Багшийн өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, бие дааж суралцах арга барилыг эзэмших үүрэгтэй,
  - 7.2.6 Сургуулиас авч буй судалгаа болон санал асуулгад түргэн шуурхай хариу өгөх үүрэгтэй,

- 7.2.7 Сургалтын төлбөрийг хугацаандаа төлөх үүрэгтэй,
- 7.2.8 Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэний улмаас явагдах зайн сургалтад идэвх хариуцлагатай оролцох, онцгой нөхцөлийн дэглэмийг чанд сахих үүрэгтэй,
- 7.2.9 Зайн сургалтын талаар дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл, зааврыг хичээл зааж буй багш, сургалтын албанаас авах эрхтэй,
- 7.2.10 Зайн сургалттай холбоотой санал, хүсэлтээ Сургуулийн захиргаанд гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй,
- 7.2.11 Интернет байнга ашиглах боломжгүй орон нутгийн оюутан зайн сургалтын хичээлийн материалыг файлаар авах эрхтэй.

## БУСАД

- 8.1. Энэхүү журмаар зохицуулагдаагүй бусад асуудлыг “ШМТДС-ийн бакалавр, магистрын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-аар зохицуулна.